

## **ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

2022 оны 03 дүгээр сарын 04-ний өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 02 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

### **НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Наймдугаар Хуралдааныг 2022 оны 02-р сарын 23-24-ний өдрүүдэд хуралдаж нийт 17 асуудал хэлэлцэж, 16 тогтоол батлав. Үүнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрмийн шинэчилсэн найруулгыг дахин боловсруулах дэд ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын даргын захирамжаар байгуулж томилохоор шийдвэрлэв.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны дэгийг шинэчлэн батлах тухай асуудлыг хэлэлцээд “Хуралдааны дэг батлах тухай” тогтоолыг 01 дүгээр тогтоолыг батлав.

3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл байгуулах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах, Хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороодын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 02 дугаар тогтоолоор батлав..

4.”Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хорооны үйл ажиллагааны журам”-ыг 03 дугаар тогтоолоор батлав. Энэхүү журмаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорооны үйл ажиллагааг зохицуулах бөгөөд Хороо нь Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангаж, Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах тухай асуудал хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс иргэд сонгогчид, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээг мөрдөн хэрэгжүүлж, хуралдаанд ажил хэрэгчээр оролцох, гарсан шийдвэр, хууль тогтоомжийг иргэд, сонгогчдод тогтмол тайлбарлан таниулж санал бодлыг нь уламжлах, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гаргасан зөрчлийг шийдвэрлэх зорилгоор “Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах тухай” тогтоолыг батлав.

6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх журам батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын зөвлөл, Хороод, Төлөөлөгчийг бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэх баталгаагаар хангах, бүх шатны ИТХ, Засаг дарга, түүний Тамгын газар, хуулийн этгээд, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд, олон нийттэй харилцаж ажиллахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилгоор “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудасны загвар, хэрэглэх журам”-ыг нэгдүгээр, аймгийн ИТХ-ын Зөвлөлийн хэвлэмэл хуудасны загварыг хоёрдугаар, Төлөөлөгчийн албан бичгийн хэвлэмэл хуудасны загварыг гуравдугаар, Хороодын хэвлэмэл хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлав.

7.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн урамшуулал олгох журам батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хуулиар олгосон эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор төлөөлөгчдөд урамшуулал олгох харилцааг зохицуулах зорилгоор “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн урамшуулал олгох журам”-ыг батлав.

8.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороодыг шинэчлэн байгуулах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-д 6 хороо, 1 дэд хороо ажиллахаар шийдвэрлэн батлав.

Үүнд:

1. Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хороо;
2. Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо;
3. Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо;
4. Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо;
5. Хот суурин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хороо;
6. Хүний эрх, өргөдөл гомдлын хороо, Ёс зүйн дэд хороо гэсэн нэртэйгээр Хурлын хороодыг шинэчлэн байгуулав.

9.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн, 2 хэлтэстэй байхаар батлав.

Ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулан Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, зөвшөөрлийг үндэслэн батлахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн даргад даалгалаа.

10.Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын ололт амжилт, үр дүнг улам бататгаж, эрчимжүүлэхийг тэмдэглээд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн дэвшүүлсэн 37 зорилт, 173 арга хэмжээний хэрэгжилтийн явц 91.45 хувийн гүйцэтгэлтэй тул “ҮР ДҮНТЭЙ” гэж дүгнэв.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд тодорхой арга хэмжээ авч, шаардлагатай төсөв хөрөнгийн асуудлыг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татан, хэрэгжилтийг бүрэн хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

11.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дэвшүүлсэн 52 зорилтын 274 арга хэмжээний хэрэгжилтийн явц 87.65 хувийн гүйцэтгэлтэй тул “ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН” гэж дүгнэв.

Аймгийг Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг бататгаж, удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэхээр тодорхой арга хэмжээ авч, шаардлагатай төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн, хэрэгжилтийг бүрэн хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

12. Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэх тухай асуудал хэлэлцээд Төв аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын ололт амжилт, үр дүнг улам бататгаж, удаашралтай зорилт, арга хэмжээг эрчимжүүлэхийг тэмдэглээд Төв аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний дэвшүүлсэн 52 зорилт, 274 арга хэмжээний хэрэгжилтийн явц 90.01 хувийн гүйцэтгэлтэй тул “ҮР ДҮНТЭЙ” гэж дүгнэв.

13.Газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудал, түүнд Хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн нутаг дэвсгэрт Хөдөө аж ахуйн газрын /бэлчээр, тариалан, хадлан/-ийн талбайн 1 га газрын төлбөрийн хэмжээ, сумын төв, суурингийн газрын үнэлгээний зэрэглэл (бүс)-ийн 1 га газрын төлбөрийн хэмжээг сум тус бүрээр баталж “Газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг батлав.

Газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын 1-27 дугаар хавсралтаар 27 сумдын төлбөрийн хэмжээг тус тус тогтоов. Шинэчлэн тогтоосон газрын төлбөрийн хэмжээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад тайлбарлан таниулж, газар эзэмшигч,

ашиглагчдын газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийж, хугацаанд нь хураан барагдуулж төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах аймгийн Засаг даргад даалгав. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг зохих журмын дагуу жил бүрийн төсөвт тусган батлуулж, зарцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгов.

14.Хөрөнгө шийдвэрлүүлэх тухай асуудал хэлэлцээд акталж устгах, худалдах, шилжүүлэх барилгыг нэгдүгээр, дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгслийг хоёрдугаар, балансаас балансад шилжүүлэх хөрөнгийг гуравдугаар, акталж устгах машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлан худалдах барилгын доорх газрын суурь үнийг барилгын үнэ дээр нэмж дуудлагын худалдаагаар худалдуулахаар шийдвэрлэв.

Дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, дуудлагын худалдаатай холбоотой гарсан зардлыг эд хөрөнгийн суурь үнэ дээр нэмж дуудах, төлбөрийг аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, акталж устгах тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

15.Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020-2021 оны гүйцэтгэл 65.9 хувьтай хэрэгжсэн тул “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэв.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс удаашралтай байгаа зорилт арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, холбогдох байгууллага болон сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн болон сумдын богино, дунд хугацааны бодлогын бичиг баримт, тухайн жилд шаардагдах хөрөнгийг төсөвт тусган хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

16.Аймгийн 2022 оны гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөөний төсөл түүнд Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлт, Хурлын Төлөөлөгчдөөс гарсан саналыг хэлэлцээд “Төлөвлөгөө батлах тухай” тогтоолыг батлав.

17.Аймгийн ИТХ-ын VII хуралдааны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 03-р тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцээд “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” тогтоолын зарим заалтад өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг батлав.

Аймгийн ИТХ-ын 8 дугаар Хуралдаанаас батлагдан гарсан шийдвэрүүдийг Khural.mn сайт болон Дотоод удирдлагын систем, аймгийн Иргэний танхим дахь Хурлын үйл ажиллагааг сурталчлах самбарт тус тус байршуулан 27 сумын ИТХ-д е-мэйл хаягаар хүргүүлж олон нийтэд сурталчилж мэдээлэх ажлын бэлтгэлийг бүрэн ханган ажиллаж байна.

Төв аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид болон 27 сумдын ИТХ-ын ХАСХОМ мэдүүлэг гаргах эрх бүхий албан тушаалтан нийт 605 мэдүүлэгч нарын хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хугацаанд гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас Эрдэнэсант сумын ИТХ-ын 13 төлөөлөгчдөд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар сургалт хийсэн.

#### **ГХУСАЗЗөвлөлийн ажлын хүрээнд:**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөлийн энэ оны анхдугаар хуралдаан 2022 оны 03-р сарын 01-ний өдөр хуралдаж 2021 оны ажлаа дүгнэж, 2022 оны төлөвлөгөөгөө баталсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөлөөс мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Цагдаагийн газар, ТВ-5 телевизтэй хамтран “Малчны баяр” нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд хүргэсэн.

## **ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:**

### **Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 65 иргэний шагналын материалыг хэлэлцүүлж, холбогдох байгууллагаас дүгнэлт авч, Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоо тогтоох захирамж, тушаалыг батлуулж, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ажилсан жилтэй уялдуулж цалингийн нэмэгдлүүдийг шинэчлэн батлуулсан.

Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж, 2022 оны төлөвлөгөөг батлуулсан.

Аймгийн Гадаад харилцааны хамтын ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит наймдугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Япон Улсын Тоттори мужийн их сургуулийн тэтгэлэг хөтөлбөр зарлагдсан. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй, шаардлага хангасан 3-н хүүхдийн материалыг Тоттори мужийн захиргаанд хүргүүлсэн.

Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, нэг удаа хуралдан, ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцэв. Мөн 2023 онд 100 жилийн ойгоо тэмдэглэх 7 суманд ой тэмдэглэх ажлын хэсэг байгуулан, ой угтсан ажлын төлөвлөгөөгөө 2022 оны 05 сарын 01-ний дотор батлуулахыг үүрэгжүүлсэн.


Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалсантай холбогдуулан 6 сумын 17 багийн засаг даргыг томилох асуудал хойшлогдоод байсныг 2022 оны 03 сарын 15-ны дотор томилохыг 6 сумын Засаг дарга нарт үүрэг болгосон.

2020 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн улс төрийн албан тушаалтны судалгааг шинэчлэн гаргаж, тэтгэмжийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэв.

Аймгийн ЗДТГ-ын бүтэц зохион байгуулалтанд өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн ЗДТГ-ын дүрэм, хэлтсүүдийн дүрэм, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан батлуулах ажлын хэсгүүдийг байгуулан ажиллаж байна.

### **Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн чиглэлээр:**

Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын хэрэгжилтийг аймгийн дүнгээр нэгтгэн гаргаж ТАЗ-д хүргүүлээ. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, ТАЗ-ийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн хүрээнд өнгөрсөн хугацаанд 92 ажлын байранд томилгоо хийгдсэн байна. ТАЗ-ийн 2021 оны 411 дүгээр тогтоолын дагуу дээрх 92 томилгооноос 82.6 хувь буюу 76 иргэн чөлөөлөгдсөн бол үлдсэн 17.39 хувь буюу 16 иргэн чөлөөлөгдөөгүй байна. (Үүнээс: 62 иргэнийг тушаалаар томилсноос 56-г чөлөөлж, 6-г чөлөөлөөгүй; 30 иргэнтэй гэрээ байгуулснаас 20-ийг цуцлаж, 10-ийг цуцлаагүй ).



Зөрчилтэй томилгоог арилгасан болон шинээр үүссэн нийт сул орон тоо 160 байна. Үүнээс захиалга өгсөн 146 ажлын байрнаас 136-г олон нийтэд зарласан бол үлдсэн 10 нь хүлээгдэж байна. Харин сул орон тоо гарснаас ТАТХ-д заасан хугацаанд захиалга ирүүлээгүй байгаа 14 ажлын байр байна. Эдгээр ажлын байруудад нийт 65 ТОГ томилогдсон байх бөгөөд үүнээс хууль тогтоожийн дагуу 43 иргэнийг ТОГ-ээр, хууль тогтоомж зөрчиж 22 иргэнийг ТОГ-ийн томилсон байна. Нутгийн захиргааны байгууллагуудаас БТСГ, ГБХЗХГ, ОНӨГ, СХДАА, СХЗХ, СХ, ТХ, УБХ, ЭМГ, Зуунмод, Лүн сумын ЗДТГ-аас зөрчилгүй гэсэн мэдээлэл өгсөн.

Төв аймгийн 174 байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны 2021 оны тайлан мэдээг нэгтгэн гаргаж ТАЗ-д хүргүүлээ. Эдгээрээс 147 байгууллага ёс зүйн зөвлөлтэй бол 27 нь ёс зүйн зөвлөлгүй байна. Байгууллагуудын ёс зүйн зөвлөлд 607 албан хаагч ажиллаж байгаагийн 106 буюу 17.46 хувь нь эрэгтэй, 501 буюу 82.53 хувь нь эмэгтэй байна. 2021 онд БЁЗЗ-д нийт 21 өргөдөл гомдол ирсний 5 нь төрийн захиргааны албан хаагч, 16 нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.

Салбар зөвлөлийн 2 дугаар хуралдаан 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдаж 1 асуудлыг хэлэлцэн, 2 асуудлын талаарх мэдээлэл сонслоо.

ТАЗСЗ-д 47 байгууллагын 242 албан хаагчид зэрэг дэв олгуулах санал ирүүлснийг тус хуралдаанаар хэлэлцээд шаардлага хангасан 46 байгууллагын 213 албан хаагчид ТЗАХ-ын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах саналыг дэмжиж, СЗ-ийн 2022 оны 07 дугаар тогтоолыг аймгийн Засаг даргад хүргүүлээ. (Үүнээс 169 албан хаагчийн зэрэг дэв ахиж, 44 албан хаагчид шинээр зэрэг дэв авчээ. Ахлах түшмэл 24, дэс түшмэл 129, туслах түшмэл 60 байна).




Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 03/3/3 тоот албан бичгээр Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын үйл ажиллагаанд “Чадахуйн зарчмын хэрэгжилт” сэдвээр хүний нөөцийн аудит хийх мэдэгдлийг ирүүлсэн. Энэ хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/95 дугаар захирамжаар бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, хүний нөөцийн аудитын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж эхэллээ.

Төрийн албаны зөвлөлөөс баталсан салбар зөвлөлийн жишиг бүрэлдэхүүний дагуу Төв аймаг дахь СЗ-ийн гишүүдийн мэдээллийг гаргаж хүргүүлээ.

Орон нутгийн өмчийн газрын 4 албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах саналыг хянаж, засч сайжруулах саналыг өглөө.

Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 11 тогтоол гаргасан бөгөөд дундажаар 77.27%-ийн хэрэгжилттэй байна. (100%-4, 70.0%-6, 30.0%-1)




Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар танилцуулбал:

№	Төрөл	Нийт тоо	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Ирсэн албан бичиг	94	76	58	18	76.31%
2	Ирсэн өргөдөл, гомдол	5		5	5	100.0%
3	Явсан албан бичиг	31	22	13	9	59.09%

Өссөн дүнгээр ТАЗ-ийн “7:4:10” цахим сургалтыг 7 удаа зохион байгуулахад холбогдох албан хаагчдыг хамрууллаа. Мөн 3 удаагийн цахим хэлэлцүүлэг, уулзалтад оролцсон.

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалт, “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн төрийн үйлчилгээний байгууллагын 9 удирдах албан тушаал (төсвийн шууд захирагч)-ын сул орон тоог нөхөх сонгон 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Шалгалтын нийлбэр дүнгээр 3 ажлын байр нөхөгдөх боломжтой болж салбар зөвлөлийн шийдвэрээр нэр дэвшүүллээ.



Төрийн захиргааны туслах түшмэлийн 96 сул орон тоог тусгай шалгалтаар нөхөх зарын дагуу бүртгэлийг 02 дугаар сарын 28, 03 дугаар сарын 01-ний өдрүүдэд хийж байна.

Төрийн албаны 2022 оны эхний ерөнхий шалгалтыг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулахаар Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас шийдвэрлэсэн бөгөөд бүртгэл 2022 оны 2 дугаар сарын 17-ны 09:00 цагаас 3 дугаар сарын 19-ний 09:00 цаг хүртэл 30 хоногийн хугацаатай цахимаар явагдаж байна. 2022.02.28-ны байдлаар 35 иргэн бүртгүүлсэн байна.

**Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, төрийн үйлчилгээний хүрээнд:**

Аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **19** байгууллага **450 гаруй** төрлийн үйлчилгээг **2849** иргэнд, өдөрт дунджаар **150-200** иргэнд хүргэн үйлчилж байна.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем /E-mongolia/- ийг нэвтрүүлж **18** байгууллагын **156** төрлийн лавлагаа мэдээллээр иргэдэд үйлчилж байгаа бөгөөд E-mongolia нэгдсэн системээр дамжуулан 02 сард аймгийн хэмжээнд **771** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ТҮНТөвийн операторуудаас **184** лавлагаа үйлчилгээ авчээ.

Харин Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **6** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан 100 хувь гүйцэтгэлтэйгээр шийдвэрлүүлсэн. Одоогийн байдлаар хугацаа болоогүй **1** гомдол байна.

Мөн байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) сайтаар дамжуулан нийт 46 иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан 42 иргэн машины татвар, торгууль төлөх, үүрэн телефоны нэгж авах, төлбөр төлөх зэрэг үйлчилгээнүүдийг авчээ.

### **МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

**Нэг. Иргэн, аж ахуй нэгжийн өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу хийгдсэн шалгалт:**

**Газар, геодези зураг зүйн хяналтын чиглэлээр** Төв аймаг дахь Цагдаагийн газраас харъяаллын дагуу шилжүүлэн ирүүлсэн тус аймгийн Баянчандмань сумын Эрдэнэ 3 дугаар багийн нутаг Харганы ам гэх газар иргэн Г зохих зөвшөөрөлгүй мод үржүүлгийн газар ажиллуулсан гэх зөрчлийг шалгахад тус иргэн нь хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй хууль бусаар 7474м<sup>2</sup> газар ашигласан нь хяналтын хэмжилтээр тогтоогдсон тул 500000 төгрөгийн торгууль оногдуулсан.

Төв аймгийн Баян сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Гранд эс би ХХК-ийн 2021 онд хийгдсэн хайгуулын ажлын тайланг хянасан. Мөн аймгийн Цагдаагийн газраас харъяаллын дагуу шилжүүлсэн Төв аймгийн Эрдэнэ, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон 7 иргэнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 6 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 200 нэгжтэй торгууль оногдуулж, 1 иргэнд холбогдох гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн. Төв аймгийн нутаг дэвсгэрт газар эзэмшигч ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 11 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг хүргүүлж, 27 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Газрын даамал нарт эрх бүхий албан тушаалтан эрх, үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөмж боловсруулж байна.

**Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр:**

Заамар суманд Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Бүрдэл майнинг ХХК, Монполимет ХХК-ийн талбайд гарсан 4 үйлдвэрлэлийн ослын мэдээллийг МХЕГ-ын холбогдох газрын дарга, улсын ахлах байцаагч нарт яаралтай мэдээллэх хуудсын дагуу болон цахим хаягаар хүргүүлсэн. Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн 2 актыг хянаж баталгаажуулсан ба 2 актыг хянаж байна.

Цагдаагийн газраас ирүүлсэн хэргийн материалд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журам зөрчсөн эсэх асуудлаар шинжээчийн дүгнэлт гарган ажиллаж байна.

Сэргэлэн суманд фермерийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Монбийф, Цэцүүх трейд ХХК-иудын хүсэлтийн дагуу үйлдвэрлэлийн осол, Хөдөлмөрийн тухай хуулийн сургалтыг зохион байгуулсан. МХЕГ-ын Тэргүүн дэд даргын баталсан удирдамжийн хүрээнд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох удирдамжийн төслийг газрын даргаар хянуулан батлуулсан. Монбийф ХХК-ийн [igov.mn](http://igov.mn) цахим системээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тоног төхөөрөмжийн гэрчилгээ олгох ажил хийгдэж байна.

**Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:**

Эрүүл мэндийн газраас гаргасан Төв аймгийн Баян суманд бүртгэгдсэн химийн бодисын хордлогын тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээ зохион байгуулах

хамтарсан удирдамжийн дагуу Төв аймгийн Баян сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт Цэцэнс Майнинг ХХК-ийн үйл ажиллагаанд Монгол улсын Шадар сайд, байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 08 дугаар тушаал болох “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын хоёрдугаар хавсралтын аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийж, Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгаль орчны багц хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд 2022 оны 02 дугаар сарын 21-ны өдөр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан.

Химийн хорт болон аюултай бодисын агуулахад хянан баталгаажуулалтыг аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр хийх тухай удирдамж батлуулж ажилласан.

***Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:***

Нийгмийн даатгалын хууль, Геологи, уул уурхайн салбарын болон холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хангах, уул уурхайн нөхөн сэргээлтийн хэмжээг нэмэгдүүлэх, байгаль орчин болон нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэн ажиллах талаар улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг Төв аймгийн нутаг дэвсгэрт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 11 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.

***Барилгын техник, харилцаа холбооны хяналтын чиглэлээр:***

Төв аймгийн Баянчандмань сумын 260 хүний суудалтай соёлын төвийн болон Баянцагаан сумын 4-р багт “Мандах бадрах булан” ХХК-ийн “Camel oil” ШТС-ийн барилга байгууламжийн хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө ба үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулж байна.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын барилга байгууламжийн ашиглалтын байдалд шалгалт хийн, ашиглалтын төлөв байдлын тухай улсын байцаагчийн 3 дүгнэлт, ашиглалтыг зогсоох тухай 1 акт тус тус хүргүүлж ажилласан.

Төв аймгийн нутаг дэвсгэрт барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх 15 ААН, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх 4 ААН, зураг төсөл зохиогч, хөрөнгө оруулагч, захиалагч 2 байгууллагад тус тус улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг хүргүүлэхээр бэлтгээд байна.

***Байгаль орчны хяналтын чиглэлээр:***

Төв аймгийн Цагдаагийн газраас харьяаллын дагуу шилжин ирсэн хориотой ан буюу тарвага тээвэрлэсэн гэх 7 иргэнд 2.100.000 торгууль, 12.580.000 нөхөн төлбөр оногдуулан, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 37 тооны тарвагыг шилжүүлсэн, зөвшөөрөлгүй 89 шуудай байгалийн ургамал арц тээвэрлэсэн 2 иргэнд 300.000 торгууль, зохих зөвшөөрөлгүй 80 ширхэг загас тээвэрлэсэн 1 иргэнд 300.000 торгууль, 320.000 нөхөн төлбөр, таван толгойн сайжруулсан түлш тээвэрлэсэн 3 иргэнд 300.000 торгууль оногдуулан, 89 шуудай арц, 80 ширхэг загасыг улсын байцаагчийн актаар хураан авч Зуунмод сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан.

Хөвсгөл аймгийн Тариалан сумаас Улаанбаатар хот чиглэлд зэрлэг гахайн мах болон чонын мах тээвэрлэсэн зөрчилд Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорт хүргүүлсэн.

***Эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн хяналтын чиглэлээр:***

Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу ундны 2 худгийн уснаас дээж авч, МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, шинжилгээний дүнгийн тухай, Гидродазайн Инноваци ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу барилгын зураг төсөлд урьдчилсан хяналт хийсэн тухай, Арга билэг, Эдельвайс, Наран Жинст, Гурван Хонгор, Харигтрейд амралт сувиллын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу улсын байцаагчийн дүгнэлт 8 гаргасан.

Сургалтын үйл ажиллагаа танхимаар хичээллэх болсонтой холбогдуулан Коронавируст халдвар /Ковид-19/-ын хүрээнд халдвар хамгааллын дэглэм сахих, урьдчилан сэргийлэх



тухай зөвлөмжийг аймгийн нийт 76 боловсролын байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн хүрээнд аймгийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллагаас хийгдэж буй ажлын талаарх мэдээллийг 2 удаа хүргүүлсэн.

Борнуур суманд УИХ-дарга Г.Занданшатарын айлчилсан төрийн тусгай хамгаалалтын хоолны хяналтыг хийж, 3 хоолны дээжийг шинжилгээнд хамруулсан. Баян сумын Цэцэнс майнинг ХХК-ийн шалтгаан тодорхойгүй хордлогод ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЭМГ, ОБГ, ЦГ-тай хамтран хяналт шалгалт хийж эрсдэлийн үнэлгээ хийж ажилласан. Барилгын зураг төсөлд улсын байцаагчийн баталгаажуулах дүгнэлт 2-г гаргаж ажилласан. Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдлын мэдээг заасан хугацаанд 2 удаа хүргүүлсэн. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн хүнсний улаан буудайн 5 дээжийг авч ургамлын эрүүл аюулгүйн үзүүлэлтээр шинжилгээнд хамруулсан.

Сорилтын нэгдсэн лаборатори нь тайлант хугацаанд **30** сорьцонд **122** үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг цаг хугацаанд нь хянаж, баталгаажуулан гаргасан. Үүнээс:

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 28 дээжинд 99 үзүүлэлт /гүний усны 12 сорьцонд 36, төвлөрсөн системийн ус 3 сорьцонд 9, хоол 10 сорьцонд 42, мах махан бүтээгдэхүүн 2 сорьцонд 8, гурилан бүтээгдэхүүн 1 сорьцонд 4 үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг, Эрүүл ахуй химийн лаборатори нь төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 2 сорьцонд 23 үзүүлэлтээр эрүүл ахуй химийн шинжилгээг тус тус хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна. Шинжилгээний дүнгээр, эерэг стандартын шаардлага хангаагүй дээж байхгүй.

### **ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, Онцгой байдлын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/03 дугаар тушаал “Баяр амралтын өдрүүдэд, үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг томилох тухай”-аар хариуцлагатай эрүүл, томилгоот ээлж, харуул манаанд томилогдсон бүрэлдэхүүнийг томилгоожуулан, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн үүргийн биелэлтийг ханган ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит “Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн”-ийг зохион байгуулахтай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-н өдрийн 3/153 тоот албан бичгийн хүрээнд “Цэргийн бие бялдар бэлтгэлийн стандарт”-ын дагуу нормчлолын шалгалт авсан.

Улсын Онцгой комиссын Нэгдсэн Шуурхай штабаас зохион байгуулсан 2 удаагийн цахим хуралд гэмтэл сааталгүй оролцсон. Аймгийн Онцгой комиссын шуурхай штабын байрлалыг Эрүүл мэндийн газарт шилжүүлэн байршуулж 70275450, 70270119, 70272517, 70272225 дугаарын утсыг мэдээлэл холбоо сүлжээний газарт дуудлага өгч хайгуул хийж холбон хэвийн ажиллагааг хангаж ажиллаа.

Онцгой байдлын газрын нөхөн хангалт Офицер бүрэлдэхүүний нөхөн хангалт 69,6%-тай, Ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалт 62,1% -тайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Онцгой байдлын газрын даргын баталсан сургуулийн жилийн хөтөлбөр, 7 хоногийн хичээлийн хуваарийн дагуу офицер ахлагч бүрэлдэхүүнд танхимын сургалтыг 4 удаа 3 цагийн сургалтаар давхардсан тоогоор 120 алба хаагчийг хамруулан зохион байгууллаа.

#### **Улсын хяналтын чиглэлээр**

Төв аймгийн Онцгой байдлын газраас гамшиг, осол гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв:

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07 ний өдөр баталсан нэгдсэн хуваарь, удирдамжийн хүрээнд Төв аймгийн хэмжээнд Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний 12 байгууллага хамрагдсанаас гал түймэр, гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 45 зөрчил илэрснээс газар дээр нь 22 зөрчлийг арилгуулж 23 зөрчилд хугацаат

үүрэг даалгавар, ЗБАШ-6-г бичиж тухайн байгууллагуудад хүргүүлэн, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж сургалт заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Шадар сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамж”аар аймгийн хэмжээнд “Sky” худалдааны төв, “Номин” худалдааны төв, “Нийтийн номын сан”, “Аймгийн музей”-д 2022 оны 01 сарын 27-28-ны өдрүүдэд, “Түлш, эрчим хүчний алба”, “Мэргэжлийн хяналтын алба” зэрэг нийт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 38 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 174 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 94 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд баригдах 1 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичиж холбогдох дансанд зураг хяналтын 50,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна. Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 18-н аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, 1 зөвшөөрөл олгож ажиллаа.

Аймгийн шуурхай штабт 8 офицер 28 удаа 672 цагийн үүрэг гүйцэтгэж үүрэг гүйцэтгэх хугацаанд иргэдээс ирсэн мэдээ мэдээллийг цаг тухай бүрт шийдвэрлэж, хойд бүсийн төвд мэдээ тайланг явуулж ажиллаа

2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Зуунмод сумын Ланс 2 дугаар багийн 8-8 тоотод оршин суух иргэн Л.Намжилын эзэмшлийн хашаа шатсаныг гал түймэр унтраах аврах 24 дүгээр ангийн 6 албан хаагч 1 техниктэй очиход иргэд гал түймрийг унтраасан байсан.

*Мал амьтны гоц халдварт өвчин:*

Баяндэлгэр сумын 2-р багийн нутаг Тахилтын ам гэх газар үйл ажиллагаа явуулдаг “Friendship” фермийн 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдөр дуудлага өгсний дагуу нэгжийн эмч үзлэг хийн дээж авч аймгийн МЭАЦТЛ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр гоц халдварт шүлхий өвчин болох нь оношлогдсон. Голомт болон сэжигтэй бүсийн 39 үхрийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Голомтод 4 үхэр өвчилсөн. Голомтын бүсийг 5 км-ээр тогтоож, 2 албан хаагч суурин 1 постонд үүрэг гүйцэтгэж байна.

Сэргэлэн сумын 5-р багийн нутаг Ар шаварт гэх газар өвөлжиж байгаа Б.Бямбасайхан, А.Наранцэцэг нарын 2 өрхөөс 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуудлага өгсний дагуу нэгжийн эмч үзлэг хийн дээж авч аймгийн МЭАЦТЛ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр гоц халдварт шүлхий өвчин болох нь оношлогдсон. Голомт болон сэжигтэй бүсийн 96 үхэр, 1669 хонь, 410 ямааг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Голомтод 2 айлын 4 үхэр, 120 хонь өвчилсөн. Голомтын бүсийг 10 км-ээр тогтоож, 5 албан хаагч суурин 1, хөдөлгөөнт 1 постонд үүрэг гүйцэтгэж байна.

Аргалант сумын 2 дугаар баг Цагаан хөтөл суурин гэх газар өвөлжиж байгаа Т.Батзоригийн 1 өрхөөс 2022 оны 02 сарын 07-ны өдөр дуудлага нэгжийн эмч үзлэг хийн дээж авч аймгийн МЭАЦТЛ-ийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр гоц халдварт шүлхий өвчин болох нь оношлогдсон. Голомт болон сэжигтэй бүсийн 13 үхрийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Голомтод 6 үхэр өвчилсөн. Голомтын бүсийг 5 км-ээр тогтоож, 2 албан хаагч суурин 1 постонд үүрэг гүйцэтгэж байна.

54 төрийн ажилтан алба хаагчдад 2 удаагийн сургалтаар “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлаа хангах”, “Гамшгаас хамгаалах тухай хууль”-р цахим сургалт зохион байгуулж холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан.

Гал унтраах өдөр тутмын дасгал сургуулийг Онцгой байдлын газрын даргаар батлуулж батлагдсан төлөвлөгөөний дагуу 28 удаа 56 цагийн дадлагыг давхардсан тоогоор 336 алба

хаагчийг хамруулан зохион байгуулж мэргэжлийн ур чадвар авхаалж самбааг дээшлүүлэн ажиллаж байна.

Салааны захирагч нарын зохион байгуулж аж ахуйн нэгжид хийгдэх тархалтын сургуулийг батлагдсан хуваарь төлөвлөгөөний дагуу гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага сургалтын төлөвлөгөө боловсруулах зааврын дагуу бичиг баримтыг боловсруулан “4 дүгээр сургууль”, “Хүмүүн ахлах сургууль”, “Хүмүүн бага сургууль”, “Хүмүүн дунд сургууль” зэрэг 4 байгууллагын объектод тархалтын сургуулийг зохион байгуулж аж ахуй нэгж байгууллагуудын 95 ажилтан алба хаагч хамрагдаж ажиллаа.

## **ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:**

### **Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:**

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 62 шийдвэр, 2 гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, эрх зүйн асуудлаар 73 хүнд хууль зүйн зөвлөгөө өглөө.

Аймгийн хэмжээнд 367 нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийг хуулийн хугацаанд гаргуулан авч, Авлигатай тэмцэх газарт тайланг хүргүүлээ.

Авлигатай тэмцэх газартай хамтран нийтийн албан тушаалтнууд болон шинээр томилогдсон төрийн албан хаагчдад авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар давтан сургалтыг 4 удаа цахимаар зохион байгуулж 346 хүнийг хамрууллаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтнуудтай “Өглөөний уулзалт” цахим арга хэмжээг зохион байгуулж 116 албан хаагчдад мэргэжил арга зүйн туслацаа үзүүллээ.

Аймгийн 38 төрийн байгууллагын 40 албан хаагчдад “Архив, албан хэрэг хөтлөлийн хууль тогтоомж” “Монгол хэлний найруулга, зөв бичих дүрэм”, “Байгууллагын архивын баримтын цахимжуулах нь” “Байгууллагын архивын нийтлэг журам” сэдвээр мэдлэг олгох сургалт зохион байгууллаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулж хэвлэмэл хуудсаны индекстэй холбоотой зөрчлийг арилгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журмын дагуу аймгийн архив, албан хэрэг хөтлөлийн хяналтын улсын байцаагч 25 сум, 34 байгууллагын хэвлэмэл хуудасны эх бэлтгэлд хяналт тавьж зөвшөөрөл олголоо.

Олон улсын хэрэглэгчийн эрхийн өдрийг тохиолдуулан “Хүүхэд эрхэм хэрэглэгч” аяныг аймгийн хэмжээнд 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 15-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатай зохион байгуулахаар сум, байгууллагад удирдамж, төлөвлөгөөг хүргүүллээ.

Зуунмод, Сэргэлэн сумын иргэдээс шатахууны үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан иргэдээс гомдол гаргасны дагуу Тэс петролиум, Шунхлай, Магнай трейд, Гор газ, Мон-Суль зэрэг шатахуун түгээх станцуудад хяналт шалгалтыг зохион байгуулж, шатахууны үнэ нэмэгдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг талаарх мэдээллийг олон нийтэд хүргэлээ.

Аймгийн нутаг дэвсгэрт албан болон хувийн хэргээр 12 улсын 151 гадаадын иргэн (хөдөлмөр эрхэлж буй 118, хөрөнгө оруулагч 10, цагаач 3, хувийн бус зорилгоор 16, түр ирэгч 2) оршин сууж байна.

### **Төрийн архивын үйл ажиллагаа:**

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 210 иргэний хүсэлтийг хүлээн авч 1348 хуулбар хувь, 100 лавлагаа, 263 сан хөмрөгийн 1093 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлж, орон нутгийн төсөвт 1.8 сая төгрөгийг орууллаа.

4 хөмрөгийн 44 хадгаламжийн нэгжийн 5691 хуудас баримтын 31270 хүний нэрийг скайнердаж программд оруулан 619 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр “Манзушир” өргөө 2 дугаар ээлж 60 айлын орон сууц “Ирксиб строй” ХХК Х№ 76, 2020-2021 оны 7 хадгаламжийн нэгж, ДГС” ХХК Х№ 76, Таван толгой түлш ХХК-ний талбайн гэрэлтүүлэг 2022 оны 2 хадгаламжийн нэгжийг тус тус хүлээн авч хадгаламжийн санд бүртгэн авлаа.

#### **Улсын бүртгэлийн чиглэлээр:**

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 61083 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 11139 газар өмчлөх эрхийн 50371 байна. 2 сард хүлээн авсан мэдүүлэг 848 байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамж, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсан, тэмдэгтийн хураамжаас нийт 52.7 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 27 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 25 нэмэлт өөрчлөлт, шинээр 26 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 1, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 7 бүртгэл хийгдлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 4 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 28 лавлагаа өгч, орон нутгийн төсөвт 7.7 сая төгрөгийг орууллаа.

#### **Цагдаагийн үйл ажиллагааны чиглэлээр:**

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 02 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 146 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 хэргээр буюу 44,4 хувиар өссөн, Гэмт хэргийн илрүүлэлт 30.9 хувьтай байна.

Гудамж талбай, олон нийтийн газар, ахуйн хүрээнд архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй зэрэг зөрчил гаргасан 23 иргэнийг эрүүлжүүлж, албадан саатуулагдсан-2, ар гэрт нь хүлээлгэн өгсөн-4, Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлагдсан-75 нийт 100 хүнийг эрүүлжүүлэх саатуулах байранд хүлээн авч, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 155 жолоочийг илрүүлж, 1305 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж хөдөлгөөнд оролцсон 25 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5870 жолоочийг 219.3 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 82 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж ажилласан.

#### **Шүүхийн шинжилгээний чиглэлээр:**

Криминалистикийн шинжилгээ-48, магадлан шинжилгээ-57, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-110, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-338, гарын хээний санг баяжуулсан дардсаар 233, мөрөөр-23, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-180, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-57, гистологийн шинжилгээ-50 тус тус хийсэн.

#### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр:**

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохиx	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
02 дугаар сард	217	141	3	355	92	263	25.9
	4587209.8	515718.5	131567.3	4971361.0	925608.8	4045752.2	

## **ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:**

### **Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр**

Аймгийн хэмжээнд 2022 онд **113.4 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхээр төлөвлөгдлөө

Үүнд:

- Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 91,0 тэрбум төгрөгөөр санхүүжих 37 төсөл, арга хэмжээ тусгагдаж 21 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирээд байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаар 6,2 тэрбум төгрөгийн 39 төсөл, арга хэмжээ
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7,5 тэрбум төгрөгийн 33 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,0 тэрбум төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 0,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээ
- 27 суманд 7,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тус тусгагдлаа.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/772 дугаар захирамжаар батлуулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн цахим тендер шалгаруулалтын [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системээр батлуулж тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг авсан. Батлагдсан төлөвлөгөөг нийтэд ил тод болгох ажлын хүрээнд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn), [www.khural.mn](http://www.khural.mn) сайтуудад байршуулан ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 53,069.8 сая төгрөгийн 94 төсөл, арга хэмжээг тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 52,914.8 сая төгрөгийн 82 төсөл, арга хэмжээг баталсан.

2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах төсөл, арга хэмжээний тендерийг зарласан. Үүнд:

### **ТЕНДЕР НЬ ЗАРЛАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ: /НИЙТ -19/**

#### **Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:**

1. Мэргэжлийн хяналтын газрын барилгын засвар /Төв, Зуунмод сум/
2. Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Төв, Зуунмод сум/
3. Дотуур байрны барилга буулгаж, шинээр барих, 160 ор /Төв, Бүрэн сум, 1-р баг/
4. Жаргалант сумын 150 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажил
5. Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Төв/
6. Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Төв, Зуунмод сум/

#### **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:**

1. Цэцэрлэгийн барилгын гадна фасад, дулаалга /Борнуур/ /сумын Засаг даргад эрх шилжүүлсэн/
2. Аймаг, сумын Онцгой комисс, шуурхай штабын автомашин шинэчлэх зардал /Баянцогт/ /сумын Засаг даргад эрх шилжүүлсэн/
3. Шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг, төсөв хийлгэх зардал /Сүмбэр сумын зам, бусад/

4. Авто замын барилгын ажил /Зуунмод, Ланс баг/
5. Төвийн авто зам дагуу явган хүний зам барилгын ажил
6. Авто замын зураг, төсөл боловсруулах ажил /Сэргэлэн, Лүн, Зуунмод/
7. Соёл амралтын хүрээлэн болон 5-р багийн айл өрхийн суурьшлын хөрсний ус шүүрүүлэх, зайлуулах шугам татах ажил /Зуунмод/
8. Зуунмод хотын нийтийн эзэмшлийн орон сууцнуудын барилгын их засварын ажлын оролцоо /сумын Засаг даргад эрх шилжүүлсэн/
9. ЕБ-ын бага сургуулийн барилгын их засвар /Эрдэнэсант сум/
10. Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар
11. Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэгийн дотор халаалтын их засвар
12. Зуунмод сумын Биеийн тамир, спортын газрын спорт заалны шалны их засвар
13. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын 2022 оны эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах

**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО ХУРАЛДАЖ, ЯАРАЛТАЙ ЗАРЛАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ: /НИЙТ 2/**

1. Өвсний үндэс хөтөлбөр "Хүмүүн" цогцолбор сургуулийн А байрыг шинэчлэн засварлах /Төв, Зуунмод сум/ -Үнэлгээний хороо хуралдаж тендерийн баримт бичиг боловсруулсан бөгөөд Өвсний үндэс хөтөлбөрөөс хянаж байгаа.
2. Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардал –үнэлгээний хороо байгуулсан бөгөөд ажлын даалгавар, техникийн тодорхойлолт зэрэг материал ирүүлээгүй.

**ҮНЭЛГЭЭ ХИЙГДЭЖ БАЙГАА ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ /НИЙТ-3**

1. Хүнсний зах орчмын гадна дулааны шугамын засвар шинэчлэлтийн ажил /Зуунмод, Номт баг/ Нээлт
2. Дотуур байрны барилга, 160 ор /Төв, Зуунмод сум, 1 дүгээр баг/
3. Баруун чиглэлд авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам, 7.1 км /төв/

**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

“Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын хүрээнд Зуунмод хотод 5 байршилд төсөл хэрэгжүүлэхээр 2022.01.10-нд Өнөөдөр сонинд зарлан 2022.02.09-нд хүсэлт хүлээн авсан. Багц-1 1-р баг, 1, 2- дугаар байр Багц-2 1-р баг, 34, 35, 36 дугаар байр Гранд мета ХХК, Багц-4-д 1-р баг, 3, 4, 5 дугаар байр Сэмүүн тайж ХХК, Багц-6 1-р баг, Мал эмнэлэг, үржлийн байр Тусгал төв ХХК санал ирүүлсэн. Тус аж ахуйн нэгжүүдтэй 3 дугаар сарын 01-нд уулзалт зохион байгуулж, нэмэлт бичиг баримт хүлээн авсанаар батламж олгохоор шийдвэрлэсэн.

2022.02.19-нд Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ Хөшгийн хөндийд Засгийн газрын ордны цогцолбор болон үндэсний хэмжээний бүтээн байгуулалтын ажлуудтай газар дээр ирж танилцан ажиллаж, зохион байгуулалтын ажилд оролцоо ажилласан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт сумдад шинээр барих болон их засвар хийгдэх ЗДТГ-ын барилгын зураг төсөл боловсруулахад шаардагдах тоо хэмжээг гарган хүргүүллээ.

Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтаар Заамар, Цээл, Угтаалцайдам, Баянцагаан сумдын эрүүл мэндийн төвийн газрын мэдээлэл, геологи, геодезийн талаарх мэдээллийг хүргүүллээ.

“Боловсролын салбарын сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” 3,4 дүгээр ээлжинд хэрэгжих төслийн хүрээнд Барилга хот байгуулалтын яамнаас ирүүлсэн 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 03/304 тоот албан бичгийг үндэслэн 15 сумын 7 сургууль, 9 цэцэрлэг, 1 дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг 2 сарын 9-нд боловсруулан хүргүүллээ.

“Сумын хөгжил, Инженерийн дэд бүтцийн хангамж” төслийг Дэлгэрхаан суманд хэрэгжүүлэхээр зураг төсөл боловсруулах даалгаврыг боловсруулан мөн тус төсөл хэрэгжихээр батлагдсан Эрдэнэсант, Баян, Бүрэн, Алтанбулаг сумдын ажлын даалгаварыг хүргүүлсэн.

Барилга хот байгуулалтын сайдын зохион байгуулсан Сумын хөгжил төслийн хүрээнд инженерийн дэд бүтцэд холбогдох иргэдийн уулзалтыг 2 сарын 10-нд Жаргалант суманд, 2 сарын 25-нд Батсүмбэр суманд хийлээ.

Төв аймаг, Сэргэлэн сум, 1 дүгээр багт байрлах “Таван толгойн түлш ХХК”-ны үйлдвэрийн гадна орчны гэрэлтүүлгийн гадна цахилгаан хангамж, Төв аймаг, Эрдэнэ сум, 5 дугаар багт байрлах “Тамган нуурын хөндий” хөдөө аж ахуйн зориулалттай гадна цахилгаан хангамж, Зуунмод, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Баянчандмань, Баянхангай, Лүн сумын авто замын гүйцэтгэлийн зураглалыг хүлээн авч мэдээллийн санд нийт 110 км замыг бүртгэж хот байгуулалт шугам сүлжээний мэдээллийн санд оруулсан. Мөн Баянчандмань сумын соёлын төвийн барилга, Сэргэлэн сум таван толгой түлш ХХК-ны Ангарын барилга болон гадна гэрэлтүүлгийн зураглалыг хүлээн авч мэдээллийн санд оруулсан

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 20212 онд 8 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 4 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.

Зураг төсөл боловсруулах даалгавар нийт 30 олголоо.

Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах шатанд байршилыг ерөнхий төлөвлөгөөний хүрээнд батлах, орон нутгийн саналыг зурагт тусгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. 2022 онд 9 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Энэ сард 9 зураг төсөл батлаад байна.

Барилга эхлүүлэх зөвшөөрөл нийт 1 олгож барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд нийт 5 барилга байгууламж ашиглалтад орууллаа.

#### **Газрын харилцааны чиглэлээр:**

Угтаалцайдам сумын нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэнд газрын харилцааны хууль журмын талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн. Мөн [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) цахим системийн хэрэглээний талаар заавар сурталчилгаа хийсэн.

16 иргэнд кадастрын мэдээллийн санд бүртгэл хийж зургийг хэвлэж өгсөн

6 иргэний газарт кадастрын хэмжилт хийсэн.

2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа Баян 8, Баянхангай 6, Баянчандмань 33, Жаргалант 18 нийт 65 нэгж талбарын газрын дуудлага худалдааны зарыг [www.mle.mn](http://www.mle.mn) сайтад баталгаажуулсан.

Аймгийн ИТХ-аар “Газрын төлбөрийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг 2022.02.24нд батлуулсан. Газрын төлбөрийн орлогыг 2022.02.28 өдрийн байдлаар 162,0 сая төгрөг аймаг сумын дансанд төвлөрүүлсэн байна.

Цар тахалын нөхцөл байдлаас хамааран шинээр томилогдсон болон газрын даамлаар ажиллах албан хаагчдад газрын кадастрын мэдээллийн системийн сургалтыг зохион байгуулахаар Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Бүрэн сумын газрын даамлаар ажиллах албан хаагчид “газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг эрхлэх” чадамжийн гэрчилгээ авах сургалтыг 14 хоногийн хугацаанд танхимаар зохион байгуулан ажилласан. Кадастрын зурган мэдээллээр давхардсан тоогоор 50 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газраас ирүүлсэн 2022 оны 1/107 дугаар чиглэлийн дагуу сумдын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэх шаардлагатай иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, нөхөн бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2021 оны 307 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг нөхөн олговортойгоор чөлөөлөх, байршил өөрчлөх, хүчингүй болгох ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/54 дүгээр захирамжаар байгуулан төлөвлөгөөг батлууллаа.

Засгийн газрын 2022 оны 51 дүгээр тогтоолоор Богдхан төмөр замын зурвас газрын чигийг баталсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/73 дугаар захирамжаар ажлын хэсгийг байгуулан 113 нэгж талбарын судалгааг гаргаж, ГЗБГЗЗГ-т хүргүүлээд байна.

#### **Орон нутгийн өмчийн чиглэлээр:**

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13 өрх

нийт 25 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулж, сарын төлбөрийг график хугацааны төлөлтөнд хяналт тавьж ажилласнаар 2022 оны 02 сарын байдлаар 25 айлын түрээсийн төлбөр 4,416,015 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө шийдвэрлүүлэхээр санал ирүүлсэн 5 сум, аймгийн 3 төсөвт байгууллагын хөрөнгийг 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Үүнд 1 барилгыг акталж устгахаар, 2 барилгыг үнэ бууруулж дуудлагын худалдаагаар худалдахаар, 1 барилгыг шилжүүлэхээр, 13 тээврийн хэрэгслийг дуудлагын худалдаагаар худалдахаар, 73,7 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмжийг шилжүүлэхээр, 62 ширхэг тавилга, тоног төхөөрөмжийг акталж устгахаар шийдвэрлэв.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлан мэдээг 27 сумын 230 байгууллагаас 12 сумын 60 байгууллагын тайлан, статистик мэдээг нэгтгээд байна. Мөн 2021 онд хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг БЗОСК-аас холбогдох гүйцэтгэлийн баримтыг хүлээлгэн өгч санхүүгийн тайланд тусгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

✓Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг угтаж 2 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж уг сургалтанд өмчийн мэрэгжилтэнгүүд бүрэн хамрагдсан.

✓Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоот хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн судалгааг нэгтгэн авч байна. Үүнд 7 сумын 14 хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл нэгтгэгдээд байна.

#### **Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн чиглэлээр:**

##### ***Газар тариалангийн хүрээнд:***

2022 онд улаанбуудай 70022 га талбайд тариалахад 10503 тн үр шаардлагатайгаас 9 сумын 76 аж ахуйн нэгж, иргэн 9229 тн үр нөөцөлсөн, дутагдаж буй 1274 тн үрийн судалгаа, 2021 оны ургацаас 64 иргэн, аж ахуйн нэгжийн нийт борлуулагдаагүй 20771 тн улаанбуудайн үрээс 16342.5 тн гурилын үйлдвэрийн стандарт хангасан судалгааг шинэчлэн гаргаж ХХААХҮЯаманд тус тус хүргүүлээ

Таримал тэжээл 30000 га талбайд тариалахад 5100 тн үр шаардлагатайгаас 3100 тн үрийг нөөцөлсөн, дутагдаж байгаа 2300 тн үрийн судалгаа нэгтгэж байна.

Төмсний үрийн шинэчлэл, нөөц бүрдүүлэх зорилгоор төмсний Гала сортын элит болон I репродукцийн стандарт хангасан 125 тн үр худалдан авах зарын дагуу төмсний үр нийлүүлэх саналыг хүлээн авч, Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнгээс 30 тн төмсний элит үр авах гэрээ байгууллаа.

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй байгаа агуулах зоорийн мэдээллийг шинэчлэлээ. 2022 оны 2-р сарын байдлаар төмс, хүнсний ногооны 81198 тн-ы багтаамж бүхий 693 зоорь, үр тарианы 89190 тн-ы багтаамжтай 84 агуулах бүртгэлтэй байна.

Хүлэмжийн төрөл, хийц, барих ашиглах арга технологи, “Хүнсний ногооны хэрэгцээ, өрхийн тариалан”, “Сармис, сонгино, байцаа, өргөст хэмх, улаан лооль, навчит ногоо, шар лууван тариалах технологи”, “Чацаргана, үхрийн нүд тариалах арга, арчилгаа” танхимын сургалт зохион байгуулж нийт 42 өрхийн тариалан эрхлэгчдийг хамрууллаа.

##### ***Мал аж ахуйн хүрээнд:***

Мал аж ахуйн хаваржилтад зориулан аймгийн Засаг даргын А/98 тоот захирамжаар өвс тэжээлийн аюулгүйн нөөцөөс “Өвс тэжээл хямдруулан олгох тухай” шийдвэр гаргаж, өвс ногоон тэжээлийн үнэ 50%-иар бууруулж, үйлдвэрийн тэжээл 1 шуудай нь 15000 төгрөгний үнээр олгох хуваарийг сумдад хүргүүлэн ажиллалаа.

“Мал оторлуулах болон отрын мал дамжин өнгөрүүлэх журам”-д нийтийн сонсгол хийлгэх чиглэлийг сумдад хүргүүлэн ажиллаж байна. Мэргэжлийн холбоод, бусад аймгуудаас санал авах төслийг хүргүүлж, саналыг аймгийн Засаг даргын Тамгын газрын [tov.gov.mn](http://tov.gov.mn) веб сайт, Хүнс, хөдөө аж ахуйн газрын нүүр хуудаст байршууллаа.

Засгийн газрын 2019 оны 343-р тогтоолын дагуу “Хонь, тэмээний ноос бэлтгэн үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2021 оны ноосны урамшуулалд хамрагдах хүсэлтэй 5633 малчин өрхийн мэдээллийг



програмд шивж, баталгаажууллалтыг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүллээ.

Мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлээс урьдчилан сэргийлэх, мал төллөлт, төл хүлээн авах бэлтгэл хангах, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

**Мал эмнэлэгийн хүрээнд:**

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2022 онд 1585.0 мян.тол мал хамруулахаар Биокомбинат ТӨХХК-тэй вакцин нийлүүлэх гэрээ байгууллаа.

Мал эмнэлгийн үйлчилгээний 90 нэгжтэй “Мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх гурвалсан гэрээ” байгуулан ажиллаж байна.

2-р дугаар сарын байдлаар гоц халдварт шүлхий өвчин 4 сумын 4 голомтод илэрч 17 үхэр, 120 хонь мал өвчилж шинж тэмдэг арилсан. Голомт, сэжигтэй бүсийн 3800 толгой үхрийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулж, Эрдэнэ, Аргалант сумд хорио цээрийн дэглэмтэй ажиллаж байна.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 123 тээврийн хэрэгсэл, нийт 269 толгой мал, мах, махан бүтээгдэхүүн 263.8 тн, 37384 ширхэг арьс шир, цагаан идээ 12.5 тн, 8.03 тн дайвар бүтээгдэхүүнд эрүүл ахуйн үзлэг хийн, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж 13 зөрчил илрүүлэн арилгуулж ажиллалаа.

Гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хоны, ямааны цэцэг, үхрийн арьс товруутах өвчний байгалын халдвар илрүүлэх шинжилгээг 12 сумаас санамсаргүй түүврийн аргаар сонгосон 480 малд хийхээр төлөвлөж дээж цуглуулах ажил 83 хувьтай байна.

**Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд:**

Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилттой уялдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/55 захирамжаар “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн тэргүүлэх чиглэлийг батлан сумдад хүргүүлэн ажиллалаа.

“Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах талаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГазартай хамтран цахим сургалт зохион байгуулж, 27 сумын ЗДТГ-ын дарга, Санхүү төрийн сангийн мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, хоршооны төлөөлөл зэрэг 425 иргэн, хуулийн этгээдийг хамрууллаа.

Уул уурхайн аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, орон нутгийн худалдан авалт болон бэлтгэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бусад сумдын бизнес эрхлэгчидтэй хамтран бэлтгэн нийлүүлэлтийг “Хамтдаа хөгжье” сургалтыг МЕРИТ төсөл хамтран зохион байгууллаа. Тус сургалтад Заамар сумын Засаг даргын Тамгын газар, ИТХ, Заамар, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр сумын 20 жижиг дунд бизнес эрхлэгчид хамрагдлаа.

**Стандарт хэмжил зүйн чиглэлээр:**

Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар хүсэлт ирүүлсэн 9 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулж Баталгаажуулалтын зөвлөлийн хурлын шийдвэрээр 7 аж ахуйн нэгж, иргэний 2 супермаркет, 1 хүнсний дэлгүүр, 1 баар, 1 амралтын газрын үйлчилгээнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаагаар олгож, стандартын шаардлага хангалтгүй үнэлэгдсэн 1 цэгт үл тохирлын мэдэгдэл хүргүүлэн ажиллалаа. Хэмжих хэрэгсэл баталгаажуулалтаар массын хэмжлийн төрлөөр худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны газрын үйл ажиллагаанд ашиглагддаг 12 жин, 2 туухай нийт 14 массын хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажууллаа. Цахилгаан хэмжүүрийн төрлөөр УБЦТС ХХКомпанитай байгуулсан гэрээний дагуу Зуунмод сумын айл өрхийн 97 ш 1 фазын цахилгаан тоолуурыг шалгаж баталгаажууллаа.

**Байгаль орчин аялал жуулчлалын салбарын хүрээнд:**

Аймгийн аялал жуулчлалын холбооны 2022 оны анхны хурлыг 02 сарын 15-ны өдөр зохион байгуулж 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажил болон 2022 оны төлөвлөгөө хэлэлцэв.

Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах /STREAM/ төслөөс Хэнтий аймгийн Чингис хотод 2 сарын 22-25нд Ойн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зохион байгуулагдахад Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Төв аймгийн ойн ангийн мэргэжилтнүүд хамрагдсан.

Аймгийн хэмжээнд орчны бохирдлыг бууруулах нийтийн цэвэрлэгээний ажлыг 12 сум зохион байгуулж ажилласан байна. Тус ажилд 117 аж ахуйн нэгжийн 1304 иргэдийн оролцоотой 950,4 тн хог хаягдлын цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Мөн нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй хог хаягдал хаясан төв аймгийн Сэргэлэн, Зуунмод сумдын 5 иргэнд хугацаатай албан шаардлагыг хүргүүлж, 56,5 тн хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулсан.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу ургамлын нөөц ашигласны төлбөрийн 15 хувь, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 хувь, газрын нөөц ашигласны төлбөрийн орлогын 15 хувь, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувь, ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, тайлагнах, мэдээллийг олон нийтэд ил тод хүргэж ажиллахад анхаарах, мөн хаврын хуурайшилт эхэлж буйтай холбогдуулан Ой хээрийн түймэр, Байгаль орчны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл хяналтыг чангатгах, Зэрлэг ан амьтдын өвөлжилт, хаваржилтын байдлыг тодорхойлж Био-техникийн арга хэмжээ авах ажлуудыг шуурхай зохион байгуулж ажиллах тухай үүрэг чиглэлийг Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 07/48 албан тоотоор сумдад хүргүүлэн ажиллав.

Тус үүрэг чиглэлийн дагуу Зэрлэг ан амьтдад зориулан биотехникийн арга хэмжээг Баянчандмань сум зохион байгуулж 172 мянган төгрөгийг зарцуулсан. Дэлгэрхаан, Лүн, Баян-Өнжүүл, Алтанбулаг зэрэг сумд биотехникийн арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна.

## **ТАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

### **Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:**

1 дүгээр сарын статистик мэдээгээр нийт 97 жирэмсэн эхийг хяналтад авснаас эхний 3 сартайд хяналтад 88.66% хамрагдаж, эрүүл мэндийн байгууллагуудын хяналтад 737 эмэгтэй байна. Нийт үзлэг 19549 ба үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 4316 буюу 22,08%, амбулаторийн үзлэг 12228 /62,55%/, идэвхитэй хяналтын 2053 /10,50%/ үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлаар 1488 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 25,4%, осол гэмтлийн дуудлага 2,02%-ийг эзэлж байна. Эмнэлэгт 1758 хүн эмчлэгдэн нийт 13583 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.7 байна. 2022 оны 2 дугаар сард Коронавируст халдвар /Ковид-19/-ын нийт 1573 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, өссөн дүнгээр 21247 тохиолдол болсон. Хариу арга хэмжээг зорилтод бүлгээр ялган тандалт хийж бүртгэн, шаардлагатай мэдээг өдөр тутам гарган ажилласан.

Батлагдсан тохиолдлын голомтын эцсийн халдваргүйтгэлийг 46 айл өрх, 235 объектод хийж гүйцэтгэсэн. Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад 02 сарын 28-ны байдлаар аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 1-р тунд 60043, 2-р тунд 57684, 3-р тунд 27092, 4-р тунд 1916 хүн хамрагдсан. Орон нутагтаа 02 дугаар сарын байдлаар Коронавируст халдвар /ковид-19/-тай 21932 өвчтөн эмчилгээнд хамрагдсанаас 21462 өвчтөн эдгэрч, 63 өвчтөн нас барсан байна.

Эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд ЭМЯ-ны 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 64 зүслэгт Компьютерт томографын оношилгооны аппаратыг АНЭ-т суурилуулж, ажиллах хүний нөөцийг чадавхижууллаа.

Сумын ЭМТөвд ажиллаж их эмч нарыг чадавхжуулах, анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын дарга, АНЭ-

ийн даргын баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу Лүн, Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн их эмч нарыг 14 хоног аймгийн Нэгдсэн эмнэлгийн тасгуудад сэлгэн ажиллуулж, дадлагажуулсан.

Сумдын Эрүүл мэндийн төвүүд, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн захиалгыг авч нэгтгэн, нийт 32 багцад 1.6 тэрбум төгрөгний худалдан авах ажиллагааны тендерийн үйл ажиллагааг tender.gov.mn сайтад нээлттэй зарлах ажлыг зохион байгуулсан.

“Аюулгүй бай - Эрүүл бай” аяны хүрээнд Зуунмод сумын ЕБС-ийн 5 сургууль, Сент паул сургууль, 6 цэцэрлэгийн эмч, нийгмийн ажилтан нийт 13 хүнд аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулж, осол гэмтлээс сэргийлэх арга хэмжээний зөвлөмж, гарын авлагаар хангалаа.

СӨБ, ЕБС-ийн эмч ажилчдад Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын чиглэлээр Эрүүл мэндийн сайдын А/36 тоот тушаал, Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны сайдын А/38 тоот тушаалын дагуу сургалт зохион байгуулж, багш сурагчдын халууныг өдөр бүр тогтмол хэмжих, амны хаалт, гар угаах зэрэг заавар зөвлөмжийг өгч, Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх гарын авлага материалыг тараасан. Мөн сургууль цэцэрлэгт тандалтын баг хавьтал судалгааг хэрхэн хийх, ойрын хавьтлыг гэрийн тусгаарлалтад авах талаар тодорхой чиглэл өгч ажиллаа.

ЕБС-ийн хичээл эхэлж байгаатай холбоотой /Ковид-19/-ын түргэвчилсэн оношлуурыг 5 ЕБС, дотуур байр, МСҮТөв, Сэнт паул, 6 цэцэрлэг, 26 сумын Эрүүл мэндийн төвд нийт 1660 ширхэг 26.560.000 төгрөгийн өртөг бүхий түргэвчилсэн тест хүргүүлсэн.

Угтаалцайдам суманд ХХААГ-аас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгийн арга хэмжээнд оролцон СЭМТ-ийн эмч, эмнэлгийн ажилтнуудтай хамтран артерийн гипертензи, чихрийн шижин, хөхний өмөн, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэг, “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяны арга хэмжээг зохион байгуулан нийт 70 гаруй иргэнийг хамрууллаа.

Улсын хэмжээнд 2,3 настай хүүхдүүдийг цэцэрлэгт авах ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг АНЭ, өрхийн Эрүүл мэндийн төв, цэцэрлэгүүдтэй хамтран зохион байгуулж, нийт 366 хүүхдийг хамрууллаа.

Зуунмод суманд батлагдсан тохиолдлын голомтын эцсийн халдваргүйтгэлийг 5 байгууллагын 1800 мк2 талбайд хийж гүйцэтгэв.

Нэгдсэн эмнэлгийн эмчилгээний хоолны хэсгээс хэвтэн эмчлүүлж байгаа бүх тасгууддаа эмчилгээний сет хоолоор үйлчилж эхэллээ.

Коронавируст халдвар батлагдсан эмнэлгийн тусламж шаардлагатай иргэдэд тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилгоор коронавирусын үзлэгийн кабинетыг ажлын цагаар угаалгын хэсэгт шилжүүлэн ажиллуулж эхэлсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн төв, Түргэн тусламжийн амилуулах нийгэмлэг, Эрүүл мэндийн газар хамтран “Яаралтай тусламжийн цогц менежмент болон магадлан итгэмжлэлийн зөвлөмж” сэдэвт бүсчилсэн ажлын байрны сургалтыг Сүмбэр, Эрдэнэ сумдад зохион байгуулан нийт 14 сумын Эрүүл мэндийн төв, 4 сувиллын нийт 50 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд онол дадлага хосолсон сургалт зохион байгуулан, чадавхижууллаа.

Цээл сумын Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж”, “Хүүхдийн сэхээн амьдруулалтын зарчимууд” сэдэвт 1 өдрийн ажлын байрны дадлагажуулах сургалт зохион байгуулж, нийт 11 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа.

МСҮТ-ийн 2-р дамжааны 68 оюутанд урьдчилан сэргийлэх үзлэг, НҮЭМ-ийн чиглэлээр сургалт зохион байгуулан, мэдлэг, хандлагыг дээшлүүллээ.

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалаар батлагдсан “Болзошгүй гамшиг, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын дагуу эрсдэлийн үнэлгээг “Цэцэнс Майнинг” ХХК-ны ажлын байранд хийхэд “БАГА” эрсдэлтэй дүгнэгдлээ. Үнэлгээний дүнд үндэслэн “Цэцэнс Майнинг” ХХК-нд Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын

газраас хамтарсан зөвлөмж хүргүүлсэн. ХХК-ны 39 ажилтанд Антифриз болон бусад химийн хортой бодисыг зориулалтын дагуу зөв хэрэглэх, хадгалах талаар сургалт зохион байгуулан, 21 төрлийн гарын авлага, материал тараалаа.

**Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр:**

2022 оны 1-р сард (30 эмнэлэг, 3 сувилал, 45 эмийн сан) эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэл, материалыг цахим мэдээлэлтэй тулган, чанарын хяналт явуулж, эмнэлзүйн болон ерөнхий шалгуурын дагуу шалгаж санхүүлт олгох зөвшөөрлийг ЭМДЕГ-т илгээн, шалгуур хангасан 45 эмийн сантай 2022 оны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ-г ЭМДЕГ-аас ирүүлсэн загварын дагуу байгуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 1 А/01 дугаар тушаалаар баталсан ЭМД-ын сангаас санхүүжүүлэх өвчний оношийн хамааралтай бүлэг, үнийн тарифын хэмжээг судлан, ЭМДЕГ-аас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалт, 4 удаагийн цахим хуралд оролцлоо.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг 166 иргэнд үзүүлж зөвлөгөө мэдээлэл өгч, өдрийн эмчилгээний болон Ковидын хэвтүүлэн эмчилсэн 120 өвчний түүх, оношлогоо шинжилгээ, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний 250 ширхэг тооцооны хуудсыг шалган баталгаажууллаа.

**Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан ТBS телевизтэй хамтран “Та ээжийгээ хэр сайн мэдэх вэ?” нэвтрүүлэг бэлтгэсэн. Нэвтрүүлэгт “Өсвөрийн сэтгүүлч” клубын дунд ангийн 3, Хүмүүн цогцолбор сургуулийн ахлах ангийн 1 нийт 4 сурагч ээжүүдийн хамт оролцож, Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр олон нийтэд хүргэх бэлтгэл ханган ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн утас-108-д хүүхдийн эрхийн зөрчлийн талаар 12 гомдол, мэдээлэл бүртгэгдэж, 10 гомдол, мэдээллийг Хамтарсан багт шилжүүлэн, 2 гомдол мэдээллийг Хүүхдийн эрхийн улсын байцаагчид шилжүүлэн Зөрчлийн хэрэг үүсгэн ажилласан. “Хүүхдийн мөнгө” зогсоох тухай 3 хүсэлт хүлээн авч судлан бүрэн шийдвэрлэсэн. Хурдан морины уралдаан хориглосон Засгийн газрын тогтоол, аймгийн Засаг даргын албан тоотын хэрэгжилтийг хангаж, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 01 зөвлөмж гарган сумдад хүргүүлж 932 иргэнд сурталчиллаа.

**Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Төв аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 151/Ш32022/00246, Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 140, Төв аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 02 дүгээр сарын 07-ны өдрийн 151/Ш32022/00631 дугаар захирамжуудын дагуу Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтнээр ахлуулсан шинжээчийн баг хүүхдийн асаргаа тогтоолгох маргаанд нөхцөл байдлын үнэлгээ хийхээр 2022 оны 02 дугаар сарын 10, 17, 24-ны өдрүүдэд Зуунмод сумын 1, 5, 6 дугаар багт оршин суух нэхэмжлэгч болон хариуцагчийн талд очиж ажиллав.

Төв аймаг дахь Цагдаагийн газар, Залуучууд хөгжлийн төвтэй хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр Зэвсэгт хүчний 334-р ангийн 34 алба хаагчид “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн ойлголт”, “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалтыг зохион байгуулан, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.

Аймгийн Цагдаагийн газар, Залуучууд хөгжлийн төвтэй хамтран зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 17, 22-ны өдрүүдэд “Гэр бүлийн харилцаа” сэдвээр Цагдаагийн газрын түр саатуулах байранд гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний зөрчлөөр 7-30 хоногоор баривчлагдсан 56 хүмүүжигчид зохион байгуулав.

**Залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журмын хэрэгжилтийг хангаж, сайн дурын ажилтны тоог нэмэгдүүлэх төлөвлөгөөт ажлын хүрээнд “Сайхан бүхнийг Сайн дураараа” сайн дурын гишүүн бүртгэх үйл ажиллагааг Төв аймаг дахь Монголын Гэр бүлийн сайн сайхны

нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4, 5-р сургуулийн ахлах ангийн 5 бүлгийн 98 сурагчдад “Өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд”, Гэр бүл төлөвлөлт болон Сайн дурын ажлын давуу тал, ач холбогдлын талаарх талаарх сургалт мэдээлэл хүргэж ажиллав. Сайн дурын ажлын давуу тал, ач холбогдлын талаар мэдээлэл хүргэж, шинээр сайн дурын 67 гишүүн бүртгэж баталгаажууллаа.

Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын хамтын ажиллагааны уулзалтыг 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, хамтын ажиллагааны санамж бичигт тусгах асуудлаар санал солилцсон.

#### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

2022 оны 2-р сарын байдлаар 1781 иргэнд 1011,2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1180 иргэнд 198,5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 250 иргэнд 42,8 сая төгрөгийн амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, 7 иргэнд 8,4 сая төгрөгийн онцгой тохиолдолын мөнгөн тэтгэмж, 9357 эхэд 1214,7 сая төгрөгийн “Алдарт эх” 1, 2-р зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж, 5578 ахмад настанд 451,3 сая төгрөгийн насны хишиг тэтгэмж, 168 ахмад настанд 24,5 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 89 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 13,6 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 5438 иргэнд 117,5 сая төгрөг, жирэмсэн 554 эхэд 44,2 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4223 эхэд 405,6 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 3 эх /эцэг/-т 0,9 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 4 ихэр хүүхдэд 8,0 сая төгрөг, 33779 хүүхдэд 6738,5 сая төгрөг нийт давхардсан тоогоох 62411 иргэнд 10279,8 сая төгрөгийг тус тус олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2022 оны 2 сард 1 удаа хуралдаж, 10 хүүхдийн хөгжлийн бэрхшээл, байнгын асаргааг сунгаж, 1 хүүхдийн хөгжлийн бэрхшээл, байнгын асаргааг тогтоож, комиссын гишүүдийн хүсэлтийн дагуу Аймгийн Засаг даргын 2022 оны 2-р сарын 15-ны өдрийн №А/85 тоот захирамжаар бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээтэй холбоотой иргэнээс ирүүлсэн 2 өргөдөл, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжтэй холбоотой 1 өргөдөл, нийт 3 иргэний өргөдөл хариу өгч ажилласан. Үүнээс 2 иргэний өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг дахин хамруулсан.

#### **Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:**

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 2-р сарын байдлаар шинээр 1 ажил олгогч, 43 иргэнийг ажил хайгчаар бүртгэсэн. Шинээр бий болсон 5 ажлын байрыг мэдээллийн санд бүртгэсэн. Нийт 33 ажил олгогчийн 95 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 30-н иргэн ажилд зуучилсан. Түр ажлын байранд ажилласан нийт 6 иргэнийг бүртгэж мэдээллийн санг үүсгэн ажилласан. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах 49 иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчилах, иргэдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор Угтаалцайдам суманд зохион байгуулагдсан “Иргэдээ сонсоё” нээлттэй хаалганы өдөрлөгт ажиллаж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг зорилтот бүлгийн 12 иргэнд хандлага өөрчлөх сургалт, сумын мэргэжилтэнд ХЗЗ-н Imis программд ажиллах зааварчилгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, эргэн төлөлтийг сайжруулах зэргээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ. Мөн Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын гаалийн хяналтын бүсэд үйл ажиллагаа шинээр эхэлж буй Гиверс ХХК-ий Япон хоолны рестораны захиалгын дагуу 13 иргэнтэй цахим ярилцлага зохион байгуулж, 3 иргэн байнгын ажлын байранд зуучлагдлаа.

Тайлант хугацаанд 28 иргэний 19539,65 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСанд төвлөрч, өссөн дүнгээр 173 иргэний 49552,65 мянган төгрөг төвлөрсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт 2 сард 28193,6 мянган төгрөг төлсөн ба өссөн дүнгээр Лел металл, Илт Гоулд, Уулс Заамар зэрэг ХХК-аас 7 иргэний 29524,2 мянган төгрөг ХЭДСанд төвлөрсөн байна.

### **Нийгмийн даатгалын талаар:**

“Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзол хангаж шинээр тэтгэвэр тогтоолгосон 75 тэтгэврийн хувийн хэргийг түүвэрлэн шалгаснаас 19 хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангаагүй зөрчил илэрснийг арилгуулахаар тэтгэврийн байцаагчид буцаан, хувийн хэрэгт бүрдүүлэн баримт бичиг шаардлага хангасан 56 тэтгэврийг хянаж тэтгэвэр авах эрхийн нөхцлийг хангаж ажиллалаа.

Тэтгэвэр олголтыг цахимаар хянах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын тэтгэвэр олголтыг шалгаж 2 тэтгэвэр авагчийн хөдөлгөөн Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллээс зөрүүтэй хийгдсэн зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчлийг байцаагч нараар арилгуулж зөвлөмж, үүрэг өгч ажиллалаа.

Сайн дурын даатгуулагчийн өглөгийг сумын нийгмийн даатгалын байцаагч нараас ирүүлсэн жагсаалтын дагуу 311 даатгуулагчийн мэдээллийг даатгуулагч нэг бүрээр нь тулган баталгаажуулсан.

2022 оны 02 дугаар сард аж ахуйн нэгж байгууллагуудын шимтгэлийн орлогоор 2.9 тэрбум төгрөг, 2 660 сайн дурын даатгуулагчдаас 189.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд үүнд 1680 малчин, 395 хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хөдөлмөр эрхлээгүй болон оюутан, бусад даатгуулагч иргэд байна.

Эрүүл мэндийн даатгалд 340 малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй 207, нийт 547 даатгуулагчийн 33,7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн. Жирэмсэн амаржсаны тэтгэмж 77 даатгуулагчид 119,2 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 234 даатгуулагчид 24,7 сая, ажилгүйдлийн тэтгэмж 66 даатгуулагчид 49, 03 сая төгрөг тус тус олголоо.

Засгийн газрын 63 дугаар тогтоолын дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврийг 2022 оны 02 дугаар сарын 01-нээс нэмэгдүүлэн Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан 15968 тэтгэвэр авагчдад 8058,6 сая төгрөгийн тэтгэврийг битүүний өдөр буюу 02 дугаар сарын 01-ний өдөр Төв аймгийн хэмжээнд бүрэн олгосон.

Засгийн газрын 63 дугаар тогтоолын дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр авч буй 16000 тэтгэвэр авагчдын 8,2 тэрбум төгрөгийн тэтгэврийн нэмэгдлийг цаг хугацаанд нь олгосон.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 243 иргэнд 25.6 сая төгрөг, жирэмсэн амаржсан 80 эхэд 123.2 сая төгрөг, 17 иргэний ар гэрт оршуулгын тэтгэмж 17 сая төгрөгийг нийт 340 даатгуулагчид 165,8 сая төгрөгийн тэтгэмж олголоо.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 54 иргэнд 129.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон. Нийгмийн даатгалын төрөлжсөн архиваас лавлагаа, тодорхойлолт 133 иргэнд олгов.

Нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн 2022 онд хэрэгжүүлэх Тэтгэврийн байцаагчдын цахим сургалтад хэлтсийн 32 байцаагч хамрагдав.

### **Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын чиглэлээр:**

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын сонгон шалгаруулалт хурлыг 3 удаа 124 цаг хуралдаж, нийт 131 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 30 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 87 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 14 иргэнийг цуцалсан байна.

Төв аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Сонгон шалгаруулах комисс томилох тухай” А/16 дугаар захирамжаар байгуулан ажлын хэсэг байгуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ба мэдрэлийн чиглэлээр 1, дотрын чиглэлээр 2, гэмтэл, мэс заслын чиглэлээр 2, нийт 5 материал битүүмжилсэн байдлаар хүлээж авч, тэнцсэн 3 эмчийн мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх ЭХМТК-т хүргэсэн.

### **Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр**

БШУ-ны сайдын “Танхимын сургалтад шилжүүлэх тухай” 2022 оны 02 сарын 20-ны өдрийн А/38 дугаар тушаалыг 46 цэцэрлэгийн 37 эрхлэгч, ерөнхий боловсролын 30 сургуулийн 30 захирал, 45 сургалтын менежерүүдэд танилцуулах цахим хурал зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл хийлээ.

Боловсролын салбарын 2.151.4 сая төгрөгийн “Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт”-ыг боловсруулан аймгийн ОНӨГ, БШУЯ-нд хүргүүлжээ.

2022 оны 2 дугаар сарын 14-ний өдөр танхимаар хичээллэж эхэлсэнтэй холбогдуулан Зуунмод сумын 3 сургуулийн багш сурагчдын ирц, ариутгал халдваргүйтлийн байдал сургуулийн үдийн цай, дотуур байрны үйл ажиллагаатай танилцлаа.

Угтаалцайдам суманд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан иргэдэд мэдээлэл хүргэж 20 эцэг эх иргэдээс санал асуулга авч, төгсөх 12-р ангийн 20 сурагчдад ЭЕШ-ын талаарх мэдээлэл хүргэлээ.

2022 оны аймгийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, сургууль, цэцэрлэгт зөвлөн туслах ажлыг эхлүүлжээ.

### **Соёл, урлагийн чиглэлээр**

Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн гишүүд хуралдаж, удирдамжийн дагуу 02 дугаар сарын 16-наас эхлэн Эрдэнэ, Борнуур сумдад байрлах ТСҮХД-ыг тооллогод хамруулсан. .

Соёлын яамнаас зохион байгуулсан “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын өнөөгийн түвшин буюу суурь нөхцөл байдал иргэдийн соёлын боловсролын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг Баянчандмань, Эрдэнэ, Зуунмод сумдын нийт 100 иргэдээс түүврийн аргаар авсан.

Сумдын соёлын төвүүдэд дутагдалтай техник, төхөөрөмж, материаллаг баазын судалгааг авч Соёлын яамны хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.

Нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад шинээр үүсэн байгуулагдсан Соёл урлагийн газрын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг танилцуулах “Өглөөний цай” арга хэмжээг 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулсан.

### **Номын сангийн чиглэлээр**

Аймгийн Нийтийн номын сан нь 2022 оны 2-р сарын байдлаар танхимаар 279-н байнгын уншигч, 534 ирэгсэд нийт 813 уншигчдад 1240 ном олгож уншуулан үйлчилжээ. Зөврийн номын сангаар сумдад 02 сарын байдлаар нийт 58 иргэнд 116 номоор үйлчилжээ.

Нийтийн номын санд хандиваар 20 ширхэг 243000 төгрөгийн ном ирсэнийг нэг бүрчилсэн бүртгэл болон электрон каталогит оруулж уншигчдын хүртээл болгоод байна.

“Хүүхдийн уншлагын танхим”-аас үлгэрээр дамжуулан хүүхдүүдээ зөв хүмүүжил төлөвшилтэй болгох ардын уламжлалт ёс заншлыг өвлүүлэн үлдээх, гэр бүл үр хүүхэддээ цаг зав гаргах хөгжил төлөвшилд нь эцэг хүний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Үлгэрийн цаг”-ийг цахимаар үзэх, боломжийг олгож Facebook хуудсанд 6 үлгэр байршуулж 660 хүүхэд, багачууд, эцэг эхчүүд, уншигчдын хүртээл болголоо.

Нийтийн номын сангийн “Цахим мэдээллийн танхим”-аас уншигч хүүхэд залуучууддаа зориулан цахим сан хөмргийн сурагчдын заавал унших номыг цувралаар Нийтийн номын сангийн Facebook хуудсанд 6-н удаа байршуулан олны хүртээл болгож 256 хандалтай байна.

Нийтийн номын сангийн “Хүүхдийн уншлагын танхим”-д сан хөмрөгийн төрөл анги болон уран зохиолын номоор “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан Монгол хэлний зөв бичих дүрэм, сурч судлах, өвлөх өвлүүлэх, эзэмших, хэрэглэх хөгжүүлэх зорилгоор уншигч, хүүхэд багачууддаа зориулж “Бидний эх хэл” сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж 85 уншигчдын хүртээл болголоо.

Их зохиолч Д.Нацагдоржийн амьдрал уран бүтээлийг иргэд, хүүхэд, залуучуудад сурталчилах зорилгоор “Очир-Эрдэнийн гэрэл” цуврал контент нэвтрүүлгийг “ТӨВ” телевиз, Д.Нацагдоржийн олон МЗЭ-ийн шагналт зохиолч, судлаач болон Баяндэлгэр сумын ЗДТГ, ЕБС-тай хамтран гаргалаа.

### **Музейн чиглэлээр**

Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Боловсролын хөтөлбөрийн хүрээнд “Төв аймгийн түүх соёл” сэдвээр соёлын өвийн мэдлэг олгох 7 цуврал хичээлийг бэлтгэн Зуунмод сумын ЕБ-ын сургуулийн 7, 8-р ангийн нийт 16 бүлгийн 417 сурагчдад “Соёлын өв гэж юу

вэ?”, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгал гэж юу вэ?” сэдвийн хүрээнд танхимын сургалтыг зохион байгууллаа. Тухайн сургалт нь 03 дугаар сард үргэлжлэн зохион байгуулагдана.

### **Театрын чиглэлээр:**

Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэстэй хамтран шинээр батлагдсан “Хөдөлмөрийн хууль”-иар мөн ХЭҮК-ын Төв аймаг дахь ахлах шинжээч “Жендер ба Хүний эрх” сэдвээр сургалтуудыг зохион байгуулж тус бүр 50-52 албан хаагч хамрагдлаа.

Улсын драмын эрдмийн театрын үйлдвэр зохион байгуулах хэлтсийн дуу шум, гэрэлтүүлэг, тайзны ажилтнууд манай аймагт хүрэлцэн ирж байгууллагын дуу, шум, гэрэл, тайзны ажилчдад мэргэжил арга зүйн чиглэл өгөх сургалтад зохион байгууллаа.

02-р сарын 22,23-ны өдрүүдэд “Зүрх зүсэм” МУСК гарч 400 хүүхдэд үйлчилсэн.

### **Сумдын соёлын төвүүд:**

12 сумын соёлын төвд 24 төрлийн соёл, урлагийн арга хэмээнд нийт 4313 иргэн хамрагдлаа. “Монголын хүүхдийн ардын урлагийн төв сан” ТББ-аас манай аймгийн Лүн суманд “Ардын аялгуу” бүсийн урлагийн наадмыг амжилттай зохион байгуулж 7 сумын 100 орчим ардын авъяастнууд оролцлоо.

Сумдын соёлын төвүүд “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд спорт бүжгийн төрлөөр болон идэвхитэй хөдөлгөөнийг дэмжин ажиллаж байна.

### **Биеийн тамир спортын хүрээнд**

Угтаалцайдам суманд зохион байгуулагдсан хэлтэс агентлагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2022.02.21-22-ны өдрүүдэд зохион байгуулж сумдын иргэдийг илүүдэл жингүй-Эртэч Монгол аянд нэгдэж байгаатай танилцан иргэдийг идэвхтэй хөдөлгөөнд уриалах дасгал хөдөлгөөн хийлгүүлэх ажлыг хамтран зохион байгуулж 76 иргэнийг хамруулсан.

Илүүдэл жингүй-Эртэч монгол аяныг 2022.02.16-наас орон даяар эхлүүлсэнтэй холбогдуулж 2022.02.26-ны өдрийн байдлаар 21 сумын 2422 иргэн энэхүү аянд нэгдэн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэж байна.



Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд УИХ-ын гишүүн Мөнхцэцэг болон UB cycling club, Дархан, Дорнодын дугуйчид, Төв аймгийн Манзуширын Баавгай клубүүд, марафон гүйлтийн шигшээ багийн тамирчид хамтарсан аялал, бэлтгэл хийлээ.




Үндэсний спортын VII их наадмын хүрээнд аймгийн мөсний шагайн харвааны тэмцээнийг 2022.02.12-13-ны өдрүүдэд УБ хотын мөсөн талбайд зохион байгуулж 8 багийн 28 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдөж улсын шигшээ наадамд оролцох тамирчдыг сонгон шалгаруулж авлаа



### **Оролцсон уралдаан тэмцээн**



1. Мөсний сурын харвааны улсын аварга шалгаруулах тэмцээн 2022.02.11-13-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 36 багийн 360 харваач оролцоноос манай баг тамирчид 3-р байранд шалгарч хүрэл медаль хүртэн үндэсний спортын наадамд оролцох тамирчдыг сонгон шалгарууллаа



2. Орхон аймагт зохиогдсон хойд бүсийн цанын өсвөр үе, насанд хүрэгчдийн нээлттэй тэмцээнд манай тамирчид 12 алт, 8 мөнгө, 5 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ.



3. "EQUIPPED powerlifting"- ийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож Алт 6, мөнгө 22, хүрэл 12 медаль авч багийн дүнгээр 1-р байр эзэлж алтан медаль хүртлээ



4. Монголын үндэсний спортын VII их наадмын өвлийн төрлүүдэд манай баг тамирчид амжилттай оролцон мөсний шагайн харвааны тамирчид багийн дүнгээр 7-р байр, Б.Уянга ахлагчтай мөсний сурын харваачид 2-р байрыг эзэлэн мөнгөн медаль хүртлээ.



Илүүдэл жингүй-Эртэч Монгол аяны хүрээнд 21 сумын 2422 иргэнийг иэдвхтэй хөдөлгөөнд хамруулан, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 1 төрлөөр зохион байгуулж 28 тамирчинг, улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 төрлөөр оролцож 31 алт, 51 мөнгө, 26 хүрэл, нийт 108 медаль хүртлээ.

### **ЗУРГАА. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:**

#### **Төсвийн орлогын талаар:**

Орлогын төлөвлөгөө 01-р сарын байдлаар орон нутаг 1444,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 1002,9 сая төгрөг төвлөрүүлж 69,4 хувьтай, 441,2 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 78,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 1103,0 сая төгрөг төвлөрүүлж 1398,8 хувьтай, 1024,2 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 451,6 сая төгрөгөөр биелж, 120.5 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Аргалант, Архуст, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-

Өнжүүл, Баянцогт, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэ зэрэг 12 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Батсүмбэр, Баян, Баянхангай, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Заамар, Лүн, Сэргэлэн, Эрдэнэсант зэрэг 13 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баянцагаан, Зуунмод зэрэг нийт 2 сум байна.

**Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:**

Сумдад 2022 оны 01 сарын байдлаар нийт 1605,2 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

-Сумдын ИТХ,ЗДТГазрын санхүүжилтэд 814,8 сая төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 790,4 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

**Өр, авлагын талаар:**

2022 оны 1-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 187,3 сая төгрөгийн авлага, 109.1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 62,4 сая төгрөг буюу 57.3 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг 0,4 сая төгрөг буюу 0.4 хувь нь цалингийн өглөг, 3.1 сая төгрөг буюу 2.8 хувь нь НДШимтгэлийн өр, 3,0 сая төгрөг буюу 2.7 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 40,2 сая төгрөг буюу 36.8 хувийг бусад өр эзэлж байна.

**ДОЛОО. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:**

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:**

“Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” –ийн 35 зорилт, 173 арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VIII хуралдаанд өргөн мэдүүлж 91.45%-тай дүгнүүлээ.

**Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн товчоо**

№	Бүлэг	Зорилтын гарчиг	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт				
					Үр дүнтэй 100%	Тодорхой үр дүнд хүрсэн 70-99%	Эрчимжүүлэх шаардлагатай 31-69%	Хэрэгжилт хангалтгүй 0-30%	Гүйцэтгэлийн хувь
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	1.1. Үндэсний бахархал, эв нэгдэл	1	4	4	-	-	-	100.0%
		1.2. Нүүдлийн соёл иргэншилт Монгол	1	2	2	-	-	-	100.0%
		1.3. Монгол хэл, бичиг	1	2	2	-	-	-	100.0%
2	Хүний хөгжил	2.1. Боловсрол	1	12	7	3	2	-	84.16%
		2.2. Эрүүл мэнд	1	9	7	-	2	-	91.54%
		2.3. Гэр бүл	1	5	5	-	-	-	100.0%
		2.4. Шинжлэх ухаан, технологи, инноваци	1	3	2	-	1	-	83.33%
		2.5. Хүнд ээлтэй амьдрах орчин	1	3	2	1	-	-	96.67%
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	3.1. Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл	1	3	2	1	-	-	90.00%
		3.2. Орлогод нийцсэн орон байр	1	2	-	2	-	-	90.00%
		3.3. Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	1	3	1	2	-	-	80.00%
		3.4. Эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг	1	2	2	-	-	-	100.0%
		3.5. Газрын харилцаа	1	6	4	1	1	-	90.00%

4	Эдийн засаг	4.1. Өсөлттэй өгөөжтэй эдийн засаг	1	5	4	1	-	-	98.00%
		4.2. Нийлүүлэгч аймгаас үйлдвэрлэгч аймаг	1	7	1	5	-	1	80.00%
		4.3. Ухаалаг санхүүгийн зах зээл	1	3	1	2	-	-	93.33%
		4.4. Бүс нутгийн хамтын ажиллагаа	1	2	2	-	-	-	100.0%
5	Засаглал	5.1. Ухаалаг засаглал	1	3	1	2	-	-	93.33%
		5.2. Ухаалаг бүтэц	1	2	2	-	-	-	100.0%
		5.3. Цахим Төв аймаг	1	3	1	2	-	-	93.33%
		5.4. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	1	5	5	-	-	-	100.0%
		5.5. Хүний эрхийг дээдлсэн нийгэм	1	2	-	1	1	-	66.93%
		5.6. Авлигагүй засаглал	1	1	1	-	-	-	100.0%
6	Ногоон хөгжил	6.1. Хүрээлэн буй орчин ногоон хөгжил	1	9	5	2	1	1	81.66%
		6.2. Ус-үнэт баялаг	1	6	6	-	-	-	100.0%
		6.3. Хариуцлагатай уул уурхай	1	7	6	-	-	1	90.00%
7	Амар тайван, аюулгүй нийгэм	7.1. Зэвсэгт хүчин	1	1	1	-	-	-	100.0%
		7.2 Хүн, нийгмийн амар тайван байдал	1	4	2	2	-	-	95.66%
		7.3. Гамшгийн эрсдэл	1	3	1	2	-	-	80.00%
		7.4.Хууль сахиулах салбарын хөгжил	1	3	1	2	-	-	82.56%
		7.5 Иргэд, байгууллага үзүүлэх эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээний чанар	1	1	1	-	-	-	100.0%
		7.6. Мэдээллийн аюулгүй байдал	1	1	1	-	-	-	100.0%
8	Бүс орон нутгийн хөгжил	8.1. Хөгжлийг тэтгэсэн дэд бүтэц-төв суурингийн хөгжил	1	14	9	3	-	2	86.34%
		8.2. Төвийн бүсийн тулгуур төв-Зуунмод хотын хөгжил	1	9	4	2	2	1	76.67%
		8.3. Төрөлжсөн аялал жуулчлал	1	3	1	1	-	1	73.33%
		8.4. Тогтвортой хөдөө аж ахуй	2	23	19	3	1	-	95.29%
<b>ДҮН</b>			<b>37</b>	<b>173</b>	<b>115</b>	<b>40</b>	<b>11</b>	<b>7</b>	<b>91.45%</b>

“Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 52 зорилт, 274 арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VIII хуралдаанд өргөн мэдүүлж 87.68%-тай дүгнүүллээ.

**“Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн товчоо**

№	Бүлэг	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Дундаж үнэлгээ
				100%	70-99%	31-69%	0-30%	
1	2	3	4	5	6	7	8	9
1	“Ковид – 19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг,	3	8	6	2	-	-	92.5%

	нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого							
2	Хүний хөгжлийн бодлого	18	67	40	13	13	1	84.68%
3	Эдийн засгийн бодлого	2	13	9	4	-	-	96.77%
4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого	3	37	26	9	2	-	91.84%
5	Ногоон хөгжлийн бодлого	5	39	22	11	2	4	84.29%
6	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	9	56	38	9	5	4	86.43%
7	Засаглалын бодлого	11	51	35	11	1	4	86.67%
8	Аймаг, сум, нийгэм, эдийн засгийн салбар үүсч байгуулагдсаны түүхт ой угтсан бүтээлч ажил	1	3	1	1	1	-	78.33%
<b>ДҮН</b>		<b>52</b>	<b>274</b>	<b>178</b>	<b>60</b>	<b>23</b>	<b>13</b>	<b>87.68%</b>

“Төв аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 50 зорилт 274 арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VIII хуралдаанд өргөн мэдүүлж 90.01%-тай дүгнүүлээ.

**Төв аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн товчоо**

№	Бүлэг	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Дундаж үнэлгээ
				100%	70-99%	31-69%	0-30%	
1	2	3	4	5	6	7	8	9
1	“Ковид – 19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	3	7	5	2	-	-	91.42%
2	Хүний хөгжлийн бодлого	18	60	39	14	6	1	88.13%
3	Эдийн засгийн бодлого	2	13	10	3	-	-	98.15%
4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого	3	38	29	9	-	-	98.15%
5	Ногоон хөгжлийн бодлого	5	39	30	4	2	3	88.07%
6	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	8	57	40	9	3	5	85.24%
7	Засаглалын бодлого	11	58	43	10	-	5	88.49%
8	Аймаг, сум, нийгэм, эдийн засгийн салбар үүсч байгуулагдсаны түүхт ой угтсан бүтээлч ажил	1	2	1	-	1	-	82.50%
<b>ДҮН</b>		<b>52</b>	<b>274</b>	<b>197</b>	<b>51</b>	<b>12</b>	<b>14</b>	<b>90.01%</b>

**1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан ([www.new.unelgee.gov.mn](http://www.new.unelgee.gov.mn))-д заасан хугацаанд тайлагналаа.

Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2021 оны жилийн эцсийн үнэлгээ 97.81 хувьтай байгаа нь тухайн оны хагас жилийн үнэлгээнээс 3.15 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт – 1:  
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт  
2021 оны жилийн эцсийн байдлаар

Хэрэгжилт гаргасан заалтын тоо		109/182
Бүрэн хэрэгжсэн	100%	165
Хэрэгжих шатанд	70%	13
Хэрэгжилт хангалтгүй	30%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй		4
Хэрэгжилтийн дундаж		97.81%

График – 1:  
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр  
2021 оны хагас бүтэн жил





График – 2:  
Сум, агентлаг, харьяа байгууллагын 2018-2021 оны жилийн эцсийн дүн



### Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Засаг даргын тусгай сан, ОНХС, Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын Бүжинхэн, Дэгдээхий, Ирээдүй, Унагалдайн андууд, Хүмүүн цэцэрлэгүүд, 4-р сургууль, 5-р сургууль, хүмүүн цогцолбор цэцэрлэгийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 3,757,720.8 төгрөгийн зөрчил илрүүлж 67,904.8 төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 504,042.2 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,185,773.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллаа.

### НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

Цэргийн штабын дарга дэд хурандаа Т.Төмөрчөдөр, Дайчилгааны офицер, хошууч Б.Бадарч, ОНХС-ын офицер, ахмад С.Солонго, Зуунмод сумын ЗДТГ-ын дарга Г.Батжаргал нар цэргийн бүртгэл явагдаж байгаа Зуунмод сумын 6 багт очиж анхан шатны цэргийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт хийж, ажил үүргийн зөвлөмж чиглэл өгч, нууц хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, ажилласан. Мөн ОНХС-ын офицер, ахмад С.Солонго,

Дайчилгааны офицер, хошууч Б.Бадарч нар Сэргэлэн сумын 5 багт цэргийн бүртгэлтэй холбоотой шалган туслахаар ажиллаж, цэргийн бүртгэлийн явцтай танилцлаа.

Аймгийн Засаг даргын Цэргийн бүртгэл явуулах тухай 2021 оны А/795 дугаар захирамжийн дагуу тоо бүртгэлийн ажлыг сумдаас авч нэгтгэх ажлыг Цэргийн штабт 2022 оны 2 дугаар сарын 09-ний өдрөөс 2 дугаар сарын 17-ныг хүртлэх хугацаанд 27 сумаас тоо бүртгэлийн дүн мэдээг маягтын дагуу хүлээн авч нэгтгэлээ. Дүн мэдээг Зэвсэгт хүчний Жанжин штабт 02 дугаар сарын 25-нд хүлээлгэж өгсөн.

Үндэсний батлан хамгаалах их сургуулийн ЭШХ-ээс ирүүлсэн Үндэсний ой санамж, Үндэсний үнэт зүйлс гэж юуг хэлэх, ямар түвшинд байна, хэрхэн төлөвшдөг, тэдгээрийн үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход чиглэсэн талаар 35 асуумж бүхий судалгааг 150 иргэнээс авч хүргүүлсэн.

Зэвсэгт хүчний 101 жил, Монгол цэргийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 02 дугаар сарын 16-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**